

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/11-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.АУДИТЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4.АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	17
5.2 Албан шаардлага	17
5.2 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТЕЗ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ГЭР БҮЛ,
ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН
ГАЗРЫН ДАРГА П.ОЮУН ТАНАА

2024.02.23 № 00А-2024/11-НА-СТА-Т143
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

ГБХЗХГ-ын нэмэлт санхүүжилтийн 100130017401 тоот дансанд ХНХЯ-аас 3,400.0 мянган төгрөг, АХБ-аас хэрэгжүүлж буй Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төслөөс 3,712.5 мянган төгрөг, Удирдлагын академиас Nextgen төслийн санхүүжилт 20,000.0 мянган төгрөг, ГБХЗХГ-аас хүүхэд харах үйлчилгээний санхүүжилт 1,736.4 мянган төгрөг, аймгийн Засаг даргын захирамжаар 2,000.0 мянган төгрөг, өмгөөлөгчийн ажлын хөлсний 700.0 мянган төгрөг зэрэг нийт 31,548.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Тус газрын үндсэн чиг үүрэгт хамаарах нөхцөл байдлын үнэлгээ хийх, хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр, гэр бүлийн хөгжил, хамгаалал гэх мэт үйл ажиллагааны төсвийг зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр бус “Бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал”-д бөөн дүнгээр баталж, шатахуун, томилолт, бараа материал, хичээл үйлдвэрлэлийн гэх зэрэг бүх зардлыг тус ангиллаас зарцуулж байгаа нь хөрөнгийн зарцуулалтад зардлын бүлгээр тавих хяналтыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь 2023 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г 4 зорилт 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93.2 хувийн биелэлттэй дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	48,572,981.00	51,366,917.00
35	БАРАА МАТЕРИАЛ	48,572,981.00	51,366,917.00
35100	Түүхий эд материал	8,167,210.00	8,061,710.00
35110	Тусгай зориулалттай материал	8,167,210.00	8,061,710.00
35400	Хангамжийн материал	40,405,771.00	43,305,207.00
35410	Бичиг хэргийн материал	129,800.00	129,800.00
35420	Аж ахуйн материал	35,035,971.00	36,888,271.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,232,000.00	1,674,000.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	633,236.00
35450	Барилгын засварын материал	3,008,000.00	2,978,000.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	1,001,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	724,704,547.05	683,040,269.73
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	724,704,547.05	683,040,269.73
39200	Биет хөрөнгө	675,202,547.05	633,538,269.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	596,803,135.60	596,803,135.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	-49,938,820.14	-68,098,391.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,500,000.00	23,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-8,322,916.78	-11,260,416.82
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	108,423,974.28	113,699,624.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	-35,504,396.45	-60,957,246.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	56,701,978.00	61,840,458.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-25,494,512.94	-30,019,760.31
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,684,631.00	18,684,631.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,725,525.52	-10,728,764.88
39217	Ном	75,000.00	75,000.00
39300	Биет бус хөрөнгө	49,502,000.00	49,502,000.00
39301	Программ хангамж	563,340.00	563,340.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-563,340.00	-563,340.00
39303	Бусад биет бус хөрөнгө	49,502,000.00	49,502,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	773,277,528.05	734,407,186.73
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	773,277,528.05	734,407,186.73
51	Засгийн газрын хувь оролцоо	773,277,528.05	734,407,186.73
51100	Засгийн газрын оруулсан капитал	200,497,379.82	200,497,379.82
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	200,497,379.82	200,497,379.82
51200	Хуримтлагдсан үр дүн	-6,659,716.48	-45,530,057.80
51210	Өмнөх үеийн үр дүн	-779,937,244.53	-6,659,716.48
51220	Тайлант үеийн үр дүн	773,277,528.05	-38,870,341.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	579,439,864.71	579,439,864.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	773,277,528.05	734,407,186.73

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,554,969,854.32	1,161,947,393.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	817,760,199.64	13,310,730.00
120	Нийтлэг татварын бус орлого	817,760,199.64	13,310,730.00

120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	774,917,433.41	7,211,630.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	42,842,766.23	6,099,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	737,209,654.68	1,148,636,663.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	687,924,100.00	1,117,087,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	687,924,100.00	1,117,087,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,285,554.68	31,548,863.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	20,615,634.68	27,112,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,669,920.00	1,736,363.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	700,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	781,692,326.27	1,200,817,734.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	781,692,326.27	1,200,817,734.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	767,204,835.96	1,095,608,747.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	406,623,127.78	610,780,846.88
210101	Үндсэн цалин	338,036,892.42	417,152,573.77
210102	Нэмэгдэл	27,245,976.36	130,965,801.47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,594,500.00	26,049,052.00
210104	Урамшуулал	23,745,759.00	36,613,419.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,262,093.99	76,634,386.54
210201	Тэтгэврийн даатгал	34,082,306.41	54,227,715.51
210202	Тэтгэмжийн даатгал	4,411,522.71	6,123,420.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,209,729.80	4,592,934.89
210204	Ажилгүйдлийн даатгал	977,021.32	1,039,889.58
210205	Эрүүл мэндийн даатгал	7,581,513.75	10,650,426.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,591,377.90	60,023,890.89
210301	Гэрэл, цахилгаан	4,007,224.32	4,053,044.81
210302	Түлш, халаалт	48,986,496.58	52,116,906.08
210303	Цэвэр, бохир ус	3,597,657.00	3,853,940.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,029,172.90	13,185,106.00
210401	Бичиг хэрэг	725,560.00	1,865,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,373,483.20	1,962,280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,489,279.70	2,450,426.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	220,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	440,850.00	1,423,900.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	5,263,500.00
2105	Нормативт зардал	189,300.00	439,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	189,300.00	439,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,734,900.00	33,140,400.00
210604	Урсгал засвар	12,734,900.00	33,140,400.00
2107	Томилолт, зочны зардал	487,450.00	254,000.00
210702	Дотоод албан томилолт	487,450.00	254,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	180,449,827.03	246,328,010.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	179,954,027.03	246,210,610.00

210803	Даатгалын үйлчилгээ	63,800.00	43,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	35,100.00	24,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	46,900.00	32,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	0.00
210807	Газрын төлбөр	0.00	17,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,837,586.36	54,823,107.32
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,624,700.00	2,744,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	50,212,886.36	52,078,407.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,487,490.31	105,208,986.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	330,000.00	3,004,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	330,000.00	3,004,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,157,490.31	102,204,986.69
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,448,948.63	102,204,986.69
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	8,708,541.68	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	773,277,528.05	-38,870,341.32
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	773,277,528.05	-38,870,341.32

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	737,209,654.68	1,148,636,663.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	737,209,654.68	1,148,636,663.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	687,924,100.00	1,117,087,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	687,924,100.00	1,117,087,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,285,554.68	31,548,863.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	20,615,634.68	27,112,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,669,920.00	1,736,363.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	700,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	737,209,654.68	1,148,636,663.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	737,209,654.68	1,148,636,663.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	721,722,164.37	1,042,931,676.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	406,619,127.78	610,780,846.88
210101	Үндсэн цалин	339,744,092.42	416,602,573.77
210102	Нэмэгдэл	25,461,276.36	131,515,801.47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,668,000.00	26,049,052.00
210104	Урамшуулал	23,745,759.00	36,613,419.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,262,093.99	76,634,386.54
210201	Тэтгэврийн даатгал	34,082,306.41	53,097,054.66
210202	Тэтгэмжийн даатгал	4,411,522.71	6,410,285.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,209,729.80	4,822,427.09
210204	Ажилгүйдлийн даатгал	777,721.32	1,095,735.33
210205	Эрүүл мэндийн даатгал	7,780,813.75	11,208,884.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,591,377.90	60,023,890.89

210301	Гэрэл, цахилгаан	4,007,224.32	4,053,044.81
210302	Түлш, халаалт	48,986,496.58	52,116,906.08
210303	Цэвэр, бохир ус	3,597,657.00	3,853,940.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,138,939.70	8,777,106.00
210401	Бичиг хэрэг	837,560.00	2,222,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,024,900.00	1,878,280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,560,479.70	2,452,426.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,716,000.00	2,024,400.00
2105	Нормативт зардал	189,300.00	967,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	189,300.00	967,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,337,100.00	38,752,400.00
210604	Урсгал засвар	14,337,100.00	38,752,400.00
2107	Томилолт, зочны зардал	416,250.00	254,000.00
210702	Дотоод албан томилолт	416,250.00	254,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	181,719,675.00	243,007,046.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	181,548,575.00	242,889,646.00
210803	Даатгалын үйлчилгээ	63,800.00	43,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	35,100.00	24,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	46,900.00	32,200.00
210807	Газрын төлбөр	25,300.00	17,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,448,300.00	3,735,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,448,300.00	3,735,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,487,490.31	105,704,986.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,330,000.00	3,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,330,000.00	3,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,157,490.31	102,204,986.69
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,448,948.63	102,204,986.69
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	8,708,541.68	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	200,497,379.82	579,439,864.71	-779,937,244.53	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	200,497,379.82	579,439,864.71	-779,937,244.53	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	773,277,528.05	773,277,528.05
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	200,497,379.82	579,439,864.71	-6,659,716.48	773,277,528.05
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	200,497,379.82	579,439,864.71	-6,659,716.48	773,277,528.05
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	200,497,379.82	579,439,864.71	-6,659,716.48	773,277,528.05
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-38,870,341.32	-38,870,341.32
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	200,497,379.82	579,439,864.71	-45,530,057.80	734,407,186.73

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,117,087,800.00	1,014,882,813.31	-102,204,986.69	90.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,117,087,800.00	1,014,882,813.31	-102,204,986.69	90.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,115,587,800.00	1,013,382,813.31	-102,204,986.69	90.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	691,903,600.00	610,780,846.88	-81,122,753.12	88.28
210101	Үндсэн цалин	464,301,600.00	416,602,573.77	-47,699,026.23	89.73
210102	Нэмэгдэл	163,075,600.00	131,515,801.47	-31,559,798.53	80.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,678,000.00	26,049,052.00	-1,628,948.00	94.11
210104	Урамшуулал	36,848,400.00	36,613,419.64	-234,980.36	99.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,637,900.00	76,634,386.54	-10,003,513.46	88.45
210201	Тэтгэврийн даатгал	58,913,900.00	53,097,054.66	-5,816,845.34	90.13
210202	Тэтгэмжийн даатгал	6,931,000.00	6,410,285.35	-520,714.65	92.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,544,800.00	4,822,427.09	-722,372.91	86.97
210204	Ажилгүйдлийн даатгал	1,386,200.00	1,095,735.33	-290,464.67	79.05
210205	Эрүүл мэндийн даатгал	13,862,000.00	11,208,884.11	-2,653,115.89	80.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,147,400.00	60,023,890.89	-10,123,509.11	85.57
210301	Гэрэл, цахилгаан	8,104,200.00	4,053,044.81	-4,051,155.19	50.01
210302	Түлш, халаалт	58,142,900.00	52,116,906.08	-6,025,993.92	89.64
210303	Цэвэр, бохир ус	3,900,300.00	3,853,940.00	-46,360.00	98.81
2104	Хангамж, бараа материалын зардал	9,157,100.00	8,777,106.00	-379,994.00	95.85
210401	Бичиг хэрэг	2,222,000.00	2,222,000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	1,879,900.00	1,878,280.00	-1,620.00	99.91
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,832,700.00	2,452,426.00	-380,274.00	86.58
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	196,000.00	200,000.00	4,000.00	102.04
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,026,500.00	2,024,400.00	-2,100.00	99.90
2105	Нормативт зардал	1,098,900.00	967,000.00	-131,900.00	88.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,098,900.00	967,000.00	-131,900.00	88.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,773,500.00	38,752,400.00	-21,100.00	99.95
210604	Урсгал засвар	38,773,500.00	38,752,400.00	-21,100.00	99.95
2107	Томилолт, зочны зардал	297,600.00	254,000.00	-43,600.00	85.35
210702	Дотоод албан томилолт	297,600.00	254,000.00	-43,600.00	85.35
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	213,833,500.00	213,458,183.00	-375,317.00	99.82
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	213,450,900.00	213,340,783.00	-110,117.00	99.95

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	265,200.00	0.00	-265,200.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	43,800.00	43,800.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	24,100.00	24,100.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	32,200.00	32,200.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	17,300.00	17,300.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,738,300.00	3,735,000.00	-3,300.00	99.91
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,738,300.00	3,735,000.00	-3,300.00	99.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,117,087,800.00	1,014,882,813.31	-102,204,986.69	90.85
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,117,087,800.00	1,014,882,813.31	-102,204,986.69	90.85
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,117,087,800.00	1,014,882,813.31	-102,204,986.69	90.85
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	85	75	10	88.24
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	42	37	5	88.10
620001	Удирдах ажилтан	1	2	-1	200.00
620002	Гүйцэтгэх ажилтан	35	26	9	74.29
620003	Үйлчлэх ажилтан	6	9	-3	150.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	42	37	5	88.10
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	15	8	7	53.33
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	27	29	-2	107.41

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,548,863.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,548,863.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29,548,863.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,548,863.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,548,863.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	31,548,863.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,548,863.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	27,112,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,736,363.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	700,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /цаашид ГБХЗХГ гэх/ нь “Гэр бүл төвтэй хүүхэд хамгаалал” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

Эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьж ажилласан байна. Үүнд:

- Гэр бүлийг дэмжих, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээг нэмэгдүүлнэ,
- Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр гэр бүлд чиглэсэн зөвлөгөө үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна,
- Хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ,
- Зорилтот бүлгийн залуучуудыг нийгэмшүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлнэ,
- Байгууллагын хүний нөөцийн тогтвортой байдлыг хангаж хөгжих боломжийг бүрдүүлнэ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна.

Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн зарим албан хаагчийн цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

ГБХЗХГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-аас дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлдэг бөгөөд тайлант онд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан хяналт, шалгалтыг гүйцэтгэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэх ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ГБХЗХГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-ын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар харьяа төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ГБХЗХГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38,293.3 мянган төгрөгөөр буюу 5.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	0.00	0.00	0.00
Бараа материал	48,573.00	51,366.90	2,793.90
Үндсэн хөрөнгө	724,704.50	683,040.30	-41,664.20
Нийт хөрөнгө	773,277.50	734,407.20	-38,870.30
Өр төлбөр	0.00	0.00	0.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	773,277.50	734,407.20	-38,870.30

Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	773,277.50	734,407.20	-38,870.30
---------------------------------------	------------	------------	------------

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Бараа материалын дансны үлдэгдэл 51,366.9 мянган төгрөг болж 2,793.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 159,952.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, 8,144.1 мянган төгрөгийн материалыг шилжүүлэн авсан болон 165,302.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 683,040.3 мянган төгрөг болж 41,664.2 мянган төгрөгөөр буурсан нь 10,414.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил үнэ төлбөргүй авсан болон 52,078.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 766,882.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас дараах байдлаар өөрчлөн баталсан байна. Үүнд:

- Цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 106,347.8 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 8,880.1 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 970.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 14,995.1 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 101.1 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 9,414.0 мянган төгрөгөөр,
- Томилолт зочны зардлыг 902.4 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 42,608.8 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 7,061.7 мянган төгрөгөөр,
- Урсгал шилжүүлгийн зардлыг 1,000.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, нийт **806,997.7** мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг 310,090.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн /цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 144,142.8 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 18,167.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 34,687.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 114,752.8 мянган

төгрөгөөр нэмэгдүүлж баталсан нь голлон нөлөөлсөн/ нийт **1,117,087.8** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,117,087.8 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр 1,017,087.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,014,882.8 мянган төгрөг буюу 90.9 хувьтай байгаа нь хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийн зардлыг 102,205.0 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Хүүхдийн хөгжил, хамгаалал	1,092,276.70	990,071.70	102,205.00	90.6
2	Залуучууд болон оюутнууд	16,035.90	16,035.90	0.00	100.0
3	Гэр бүлийн хөгжил, хамгаалал	8,775.20	8,775.20	0.00	100.0
	Дүн	1,117,087.80	1,014,882.80	102,205.00	90.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130017401 тоот дансанд ХНХЯ-аас 3,400.0 мянган төгрөг, АХБ-аас хэрэгжүүлж буй Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төслөөс 3,712.5 мянган төгрөг, Удирдлагын академиас Nextgen төслийн санхүүжилт 20,000.0 мянган төгрөг, ГБХЗХГ-аас хүүхэд харах үйлчилгээний санхүүжилт 1,736.4 мянган төгрөг, аймгийн Засаг даргын захирамжаар 2,000.0 мянган төгрөг, өмгөөлөгчийн ажлын хөлсний 700.0 мянган төгрөг зэрэг нийт 31,548.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу ГБХЗХГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

ГБХЗХГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 772,983.8 мянган төгрөгөөс **1** хувиар буюу **7,729.8** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 01/385 дугаар албан бичгийг хэрэгжүүлж, дараах арга хэмжээг авсан байна. Үүнд:

- Тайлан болон хугацаатай албан бичгийн хариу гаргахаас бусад тохиолдолд цахим шуудангаар харьцаж бичгийн цаасны хэрэглээг багасгасан,
- Баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, байгууллагын ой зэргийг зохион байгуулаагүй,
- Зочид, төлөөлөгч хүлээн авах, үдэх, бэлэг дурсгалын зүйлсэд зардал гаргаагүй,
- Ажлын цагийн дараа компьютер, техник хэрэгслүүдийг бүрэн унтрааж ажилласнаар нийт тогтмол зардлыг 9,5 сая төгрөг буюу 18,7 хувь хэмнэсэн,
- Төрийн өмчид бүртгэлтэй авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэж эхэлсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд ГБХЗХГ-ын мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллээс 168 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,760.0	1	1,760.0	100.0
Албан шаардлага	1	1,677.5	1	1,677.5	100.0
Зөвлөмж	1	16,591.5	1	16,591.5	100.0
Нийт дүн	3	20,029.0	3	20,029.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

- Тус газрын үндсэн чиг үүрэгт хамаарах нөхцөл байдлын үнэлгээ хийх, хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр, гэр бүлийн хөгжил, хамгаалал гэх мэт үйл ажиллагааны төсвийг зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр бус “Бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал”-д бөөн дүнгээр баталж, шатахуун, томилолт, бараа материал, хичээл үйлдвэрлэлийн гэх зэрэг бүх зардлыг тус зардлын бүлгээс зарцуулж байгаа нь хөрөнгийн зарцуулалтад зардлын бүлгээр тавих хяналтыг алдагдуулж байна.

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,221.9 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн шинж чанартай 5,562.8 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэж, тайлагнасан,
- 9 нэр төрлийн үндсэн хөрөнгөд 257.2 мянган төгрөгийн элэгдэл тооцоогүй,
- Бараа материалын тодруулгад 401.9 мянган төгрөгийн бараа материалын ангиллыг зөрүүтэй тайлагнасан.

Аудитаар нийт **4,584.3** мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,017.6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 3,566.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Нягтлан бодогч Б.Сарнайн ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 40.0 хүртэл хувиар тооцож үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр **1.5** сарын үндсэн цалин буюу **1,017.6** мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3. “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. Батлагдсан төсвийг зориулалт бусаар, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, бодитоор тайлагнаагүй **3,566.7** мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан,

мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасныг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Тус байгууллагын дарга болон 2 албан хаагчид “Аймгийн шилдэг байгууллага”-аар шалгарсан, “Байгууллагын аварга ажилтан”-аар шалгарсан гэх үндэслэлээр цалингийн зардлаас шагналын зардалд 3,038.7 мянган төгрөг,
- Нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас албан хаагчдад малгай, фудволк худалдан авахад 528.0 мянган төгрөг зэрэг.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шаардлагатай бол төсөвт зохицуулалт хийлгэх албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа **43** нэр төрлийн хөрөнгийг /Нийт хөрөнгийн 24.9 хувь/ бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлүүлэх, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтын дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дүгээр сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн.		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн	1	5,562.8					1	5,562.8				
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцоогүй	1	257.2					1	257.2				
Бараа материалын ангиллыг зөрүүтэй тайлагнасан	1	401.9					1	401.9				
Дүн	3	6,221.9					3	6,221.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Урамшуулал давхардуулан олгосон	1	1,017.6	1	1,017.6									
Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	3,566.7			1	3,566.7							
Ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны ертгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй	1						1						
Дүн	3	4,584.3	1	1,017.6	1	3,566.7	1						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны 3 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн	1						1	
Нийт дүн	1						1	